

# СЗМ-ЗБЭДХ Анхдагч өглөгт тооцогдох зээл-ХасБанк II (EFSD+1)

Байршил: Монгол улс

Төслийн дугаар: 57050

Бизнесийн салбар: Хадгаламжийн Зээл (Банк)

Мэдээллийн төрөл: Хувийн

Байгаль орчны нөлөөллийн ангилал: СБ

Батлагдах огноо: 2026 оны 05 дугаар сарын 14

Төлөв байдал: Судалгааны шатанд

Англи хэл дээр нийтэд ил болгосон өдөр: 2026 оны 04 дугаар сарын 09

## Төслийн танилцуулга

Төв Азийн Залуу бизнес эхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд (ТА ЗБЭДХ) ХасБанк ХК-д (ХасБанк) 80 сая ам.доллар хүртэлх анхдагч өглөгт тооцогдох, барьцаагүй зээлийг ам.доллараар эсвэл төгрөгөөр олгох төсөл. Уг зээл нь Монгол дахь залуучуудын удирдсан эсвэл залуучуудын эзэмшдэг ЖДББ-г дэмжих зорилготой. (Залуу ЖДББ-ууд)

## Төслийн зорилго

Төсөл нь залуу ЖДББ-уудын зээлийн хүртээмжийн хомсдлыг шийдвэрлэж, Монголд тэдний өсөлт хөгжилд тургарч буй бүтцийн саад бэрхшээлийг арилгахад хувь нэмрээ оруулна. Төсөл нь залуучуудад чиглэсэн тогтвортой зээлийн үйл ажиллагааг дэмжих банкны дэд бүтцийг бэхжүүлэх, нутагшуулахад анхаарч, ХасБанкны онцлогт нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, дэмжих үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын ЖДББ-ийн зах зээлд залуу бизнес эрхлэгчдийн урт хугацааны оролцоог хангахад чиглэнэ.

## Шилжилтийн нөлөөлөл

Төслийн шилжилтийн үр нөлөө нь Хүртээмж болон Өрсөлдөх чадвар гэсэн шинж чанарт тулгуурлана. Энэхүү санхүүжилт нь Монгол Улсад залуу ЖДББ-ууд руу чиглэсэн зээлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ХасБанкны чадавхыг бэхжүүлж, залуу бизнес эрхлэгчид болон менежерүүдийг санхүүгийн бус үйлчилгээ (NFS)-ээр дамжуулах чадавхжуулах.

## Харилцагчийн мэдээлэл

ХАСБАНК ХК

ХасБанк ХК нь 2025 оны эцсийн байдлаар нийт 1.9 тэрбум ам.долларын нийт хөрөнгөтэй, 1.2 тэрбум ам.долларын зээлийн багцтай, зах зээлийн ойролцоогоор 9 хувийн эзэлдэг Монгол Улсын дөрөв дэх том арилжааны банк юм. ХасБанк нь голчлон ЖДББ болон иргэдийн зээлд анхаарч, улс даяар 71 салбараар дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.

### **ЕСБХБ-ны Санхүүжилтийн дүн**

80,000,000.00 ам.доллар

### **Төслийн нийт өртөг**

80,000,000.00 ам.доллар

### **Нэмэлт үр дүн**

*Инновацлаг санхүүжилтийн бүтэц ба/буюу санхүүгийн хэрэгсэл:* ЕСБХБ нь зах зээл дээр түгээмэл бус нөхцөл, хугацаатай, тэр дундаа төгрөгөөр олгох санхүүжилтыг санал болгож байна. Мөн харилцагч нь Эхний Алдагдлын Эрсдлийн Хамгаалалт (FLRC) болон Гүйцэтгэлд суурилсан нөхөн олговор (RBC) зэрэг Төв Азийн зах зээлд зориулан боловсруулсан, шинэлэг хэрэгслүүдээс ашиг тус хүртэх боломжтой.

*Мэдлэг ба инновац, чадавх бэхжүүлэх:* ЕСБХБ нь төслийн зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой мэдлэг, инновац, туршлага, чадавхыг олгодог. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд ХасБанк болон залуу ЖДББ-уудад сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар чадавх бэхжүүлэх дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлж, орон нутгийн хамрах хүрээг тэлэх, залуу бизнес эрхлэгчдийг илүү өргөнөөр татан оролцуулахыг зорьж байна.

*Стандарт тогтоох:* “Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”

(ТА ЗБЭДХ) нь харилцагч санхүүгийн байгууллагуудын (ХСБ) хүртээмжийн стандартыг дээшлүүлэх цогц аргачлалыг багтаадаг. Санхүүжилт, Эхний Алдагдлын Эрсдэлийн Хамгаалалт (FLRC), Гүйцэтгэлд суурилсан урамшуулал (RBC) болон техникийн хамтын ажиллагаа (ТС)-г хослуулснаар уг хөтөлбөр нь ХасБанканд залуу бизнес эрхлэгчдийн хэрэгцээг илүү гүнзгий ойлгож, улмаар хүртээмжтэй санхүүжилтийн стандартаа бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### **Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй**

(БОНБ 2024)-ийн дагуу Санхүүгийн байгууллага (СБ) ангилалд хамаарагдсан. Харилцагч нь Банкны харилцагч бөгөөд байгаль орчны болон нийгмийн шаардлагуудыг хангаж ирсэн. Дамжуулан санхүүжүүлж буй төслүүд нь голчлон байгаль орчин, нийгмийн (БОН) эрсдэлийн багаас дунд түвшний ангилалд

хамаарах бөгөөд ихэвчлэн залуучуудын эзэмшилтэй эсвэл залуучуудын удирддаг ЖДББ-уудын санхүүжилтэд зарцуулагдана. Үндсэн БОН эрсдэл нь санхүүжүүлсэн дэд зээлүүдтэй холбоотой бөгөөд хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй байдал, мөн дэд зээлдэгчдийн дагаж мөрдөх үндэсний хууль тогтоомж БОНБ, хөдөлмөр аюулгүй байдлын шаардлагыг мөрдөхтэй холбоотой асуудлуудыг хамарна. Харилцагч нь ЕСБХБ-ний санхүүжүүлж буй багцын эрсдэлийн түвшинд тохирсон Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоотой бөгөөд энэхүү тогтолцоог хадгалах үүрэгтэй. Мөн ЕСБХБ-ний Гүйцэтгэлийн шаардлага 2, 4 болон 9-т нийцүүлэн хүний нөөцийн зохистой бодлого, гомдол шийдвэрлэх хэрэгсэл, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журам зэрэг холбогдох журмуудыг баримталж ажиллах шаардлагатай. Түүнчлэн харилцагч нь жил бүр БОН-ын тайлан, ЕСБХБ-ний Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу өөрийн Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны талаарх мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.

### **Ногоон үнэлгээ:**

Төслийг шууд бус санхүүжилтэд зориулсан ЕСБХБ-ны Парисын хэлэлцээртэй нийцүүлэх аргачлалыг ашиглан үнэлсний үндсэн дээр Парисын хэлэлцээртэй нийцтэй гэж тодорхойлсон. Үүнд: (i) санхүүжилтийн зориулалт тодорхой байх, (ii) хориглосон жагсаалт болон (iii) бага хүлэмжийн хийн ялгаруулалттай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийн шилжилтэд чиглэсэн санхүүгийн урсгалыг бий болгохын тулд ЕСБХБ -тэй хамтран ажиллах харилцагчийн амлалт багтана.

### **Техникийн туслалцаа ба буцалтгүй тусламжийн санхүүжилт**

Зээлийг (i) Европын Тогтвортой Хөгжлийн Сангийн Нэмэх (EFSD+) хөтөлбөрөөр дамжуулан ЕХ-ноос санхүүжих, ХасБанкинд олгох Эхний Алдагдлын Эрсдэлийн Хамгаалалт (FLRC), мөн (ii) ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн Тусгай Сангаас санхүүжих, ХасБанкинд олгох Гүйцэтгэлд суурилсан урамшуулал (RBC)-аар дэмжинэ.

Хосолсон техникийн хамтын ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүд нь залуу бизнес эрхлэгчдийн дундах хүртээмж багатай бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагын талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах замаар ХасБанкны хүртээмжтэй санхүүжилтийн стандартыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### **Компаний холбоо барих хүний мэдээлэл**

Тамир Ганхуяг

[tamir.g@xacbank.mn](mailto:tamir.g@xacbank.mn)

+(976) 7577-1888

<https://www.xacbank.mn/en>

Улаанбаатар, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А,  
72

## Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

## Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: [projectenquiries@ebrd.com](mailto:projectenquiries@ebrd.com)

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: [procurement@ebrd.com](mailto:procurement@ebrd.com)

## Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

## Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх

эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

## **Бүрэн төгс байдал ба комплаенс**

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд [compliance@ebrd.com](mailto:compliance@ebrd.com) цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

## **Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)**

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг

тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

## Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол [ipam@ebrd.com](mailto:ipam@ebrd.com) цахим шуудангаар хандаж болно.